



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Гурванбулаг сумын ЭМТ-ийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2024/89/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Булган аймаг

2025 он

Булган аймаг дахь ТАГ-ын дарга,
тэргүүлэх аудиторовын албан тушаалын албан үүргийг түр орлон
гүйцэтгэгч : Ж.Энхцоодол

Утас: 70342580 Цахим хаяг: EnkhtsoodolJ@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 70342716 Цахим хаяг: EnkhtsoodolJ@audit.gov.mn

Майкрофт аудит ХХК аудитор: Г.Майцэцэг

Утас: 89107138 Цахим хаяг: gombodorjmaitsetseg@gmail.com

Ахлах Аудитор: Б.Нарантуяа

Утас: 99138050 Цахим хаяг: narannarka18@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан

 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс:7034-2580
Цахим шуудан:bulgan@audit.gov.mn

2025.02.20

№

85

танай

ны №

г

**ГУРВАНБУЛАГ СУМЫН ЭМТ-ИЙН
ДАРГА А.ЛХАМДУЛАМ ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гурванбулаг сумын ЭМТ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гурванбулаг сумын ЭМТ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Гурванбулаг сумын ЭМТ нь гүйцэтгэлийн санхүүжилтээр санхүүжиж, 1 хөтөлбөр 4 зориулалт арга хэмжээний хүрээнд 1,667,581.6 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 1,142,475.6 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулжээ.

Тайланд онд 71,640.7 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн бөгөөд 129,993.5 мянган төгрөгийн хөрөнгийг актласан байна.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн

байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Гурванбулаг сумын Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 09-ний А/05 тоот захирамжаар 29 хүний бүтэц орон тоотой үйл ажиллагаа явуулахаар баталж, 2024 онд 22 орон тоотой үйл ажиллагаагаа явуулжээ.

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжтой нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ТУШААЛЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  ЖЭНХЦООДОЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	207,339,055.62	291,811,741.24
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	107,437,785.60	5,267,981.63
311	Кассанд байгаа бэлэн мөнгө		
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	107,437,785.60	5,267,981.63
3121	Төгрөг	107,437,785.60	5,267,981.63
31211	Төрийн сангийн харилцах	107,437,785.60	5,267,981.63
314	Замд яваа мөнгөн хөрөнгө		
33	АВЛАГА	17,943,059.00	212,501,385.51
332	Төлбөртэй үйлчилгээний авлага	16,288,605.00	210,846,931.51
335	Бусад авлага	1,654,454.00	1,654,454.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1,654,454.00	1,654,454.00
34	УРЬДЧИЛГАА		
35	БАРАА МАТЕРИАЛ	81,958,211.02	74,042,374.10
351	Түүхий эд материал	63,270,198.33	51,088,872.83
3511	Тусгай зориулалттай материал	28,085,724.43	27,798,724.43
3513	Эм боох материал	35,184,473.90	23,290,148.40
354	Хангамжийн материал	18,688,012.69	22,953,501.27
3541	Бичиг хэргийн материал	351,000.00	872,000.00
3542	Аж ахуйн материал	14,636,974.09	19,695,149.27
3546	Хүнсний материал	3,700,038.60	2,386,352.00
36	НӨӨЦИЙН БАРАА		
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	679,210,684.25	685,070,890.35
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ		
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	679,210,684.25	685,070,890.35
392	Биет хөрөнгө	664,330,684.25	670,190,890.35
39201	Барилга, байгууламж, орон сууц	802,853,394.86	802,317,641.86
39202	Хуримтлагдсан элэгдэл	-320,616,646.37	-332,410,245.22
39203	Авто-тээврийн хэрэгсэл	126,144,434.00	106,474,126.50
39204	Хуримтлагдсан элэгдэл	-87,627,767.06	-60,832,470.54
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	287,192,380.99	266,825,884.06
39206	Хуримтлагдсан элэгдэл	-157,483,939.54	-123,755,522.36
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	44,126,926.91	26,346,735.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-30,258,099.54	-14,775,259.45
393	Биет бус хөрөнгө	14,880,000.00	14,880,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	14,880,000.00	14,880,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	886,549,739.87	976,882,631.59
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,241,948.39	26,663,445.34
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,241,948.39	26,663,445.34
413	Өглөг	1,241,948.39	26,663,445.34
4131	Ажилчидтай холбогдсон өглөг	1,241,948.39	24,834,485.34
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг		1,462,860.00

4136	Бусад өглөг		366,100.00
41361	Байгууллагад төлөх өглөг		306,100.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг		60,000.00
414	Урьдчилж орсон орлого		
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
422	Урт хугацаат зээл		
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	885,307,791.48	950,219,186.25
51	Засгийн газрын хувь оролцоо	885,307,791.48	950,219,186.25
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	276,351,125.19	276,351,125.19
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө		
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө		
51101	Өмч: - төрийн	261,471,125.19	261,471,125.19
512	Хуримтлагдсан үр дүн	407,428,257.47	472,339,652.24
5121	Өмнөх үеийн үр дүн	407,428,257.47	407,428,257.47
5122	Тайлант үеийн үр дүн		64,911,394.77
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	201,528,408.82	201,528,408.82
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	886,549,739.87	976,882,631.59

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,080,053,812.75	1,292,179,535.95
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	337,019,022.50	107,830,619.04
120	Нийтлэг татварын бус орлого	337,019,022.50	107,830,619.04
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,488,040.00	50,515,300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,488,040.00	50,515,300.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	313,664,678.00	29,258,766.50
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	20,866,304.50	28,056,552.54
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	743,034,790.25	1,184,348,916.91
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	57,026,000.00	
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	57,026,000.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	16,288,605.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,288,605.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		64,718,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		64,718,300.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	669,720,185.25	1,119,630,616.91
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	669,720,185.25	1,119,630,616.91
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	867,601,230.99	1,227,268,139.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	867,601,230.99	1,226,848,139.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	866,158,397.70	1,225,801,464.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	452,444,116.91	738,169,360.08
210101	Үндсэн цалин	272,393,989.12	432,849,608.95

210102	Нэмэгдэл	131,331,635.29	231,589,319.13
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,549,995.02	12,608,000.00
210104	Урамшуулал	44,168,497.48	61,122,432.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,841,308.25	106,600,604.54
210201	Тэтгэврийн даатгал	32,733,208.66	78,349,404.54
210202	Тэтгэмжийн даатгал	4,748,165.48	7,062,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,974,298.59	3,531,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	851,333.67	3,531,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,534,301.85	14,125,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,295,306.71	62,856,224.89
210301	Гэрэл, цахилгаан	5,314,806.71	5,431,911.89
210302	Түлш, халаалт	46,979,800.00	57,424,313.00
210303	Цэвэр, бохир ус	700	
2104	Хангамж, бараа материалын зардал	36,714,714.68	44,184,545.52
210401	Бичиг хэрэг	4,336,600.00	3,413,600.00
210402	Тээвэр, шатахуун	19,580,700.00	22,976,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,260,626.00	3,627,990.70
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,057,099.05	10,346,954.82
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,479,689.63	3,820,000.00
2105	Нормативт зардал	158,672,509.30	165,012,412.64
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	135,894,077.20	152,684,206.04
210502	Хоол, хүнс	15,649,432.10	12,328,206.60
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,129,000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,693,076.15	29,395,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,767,276.15	83,600.00
210604	Урсгал засвар	12,925,800.00	29,311,400.00
2107	Томилолт, зочны зардал	5,404,000.00	5,967,000.00
210701	Гадаад албан томилолт		240,000.00
210702	Дотоод албан томилолт	5,404,000.00	5,727,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,538,850.00	8,205,758.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,213,400.00	7,673,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	133,950.00	133,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	163,500.00	84,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		180,000.00
210807	Газрын төлбөр	28,000.00	67,508.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	93,554,515.70	65,410,558.57
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,292,081.37	50,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	90,262,434.33	65,360,558.57
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,442,833.29	1,046,675.11
2132	Бусад урсгал шилжүүлэг		
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,442,833.29	1,046,675.11
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,442,833.29	1,046,675.11

	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		420,000.03
	Дотоод эх үүсвэрээр		420,000.03
222001	Тоног төхөөрөмж		420,000.03
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	212,452,581.76	64,911,396.57
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	13,144.23	1.8
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	13,144.23	1.8
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-13,144.23	-1.8
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	212,439,437.53	64,911,394.77

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	729,234,225.25	1,040,305,890.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,488,040.00	50,515,300.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,488,040.00	50,515,300.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,488,040.00	50,515,300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,488,040.00	50,515,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	726,746,185.25	989,790,590.40
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	57,026,000.00	
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	57,026,000.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		64,718,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		64,718,300.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	669,720,185.25	925,072,290.40
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	669,720,185.25	925,072,290.40
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	704,538,055.77	1,100,093,694.37
21	УРСГАЛ ЗАРДАЛ	704,538,055.77	1,100,093,694.37
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	703,095,222.48	1,099,047,019.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	448,349,117.91	730,062,587.67
210101	Үндсэн цалин	263,356,365.03	424,742,836.54
210102	Нэмэгдэл	136,274,260.38	231,589,319.13
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,549,995.02	12,608,000.00
210104	Урамшуулал	44,168,497.48	61,122,432.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,599,358.86	90,638,800.00
210201	Тэтгэврийн даатгал	35,624,736.49	62,387,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,614,688.26	7,062,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,974,298.59	3,531,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	851,333.67	3,531,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,534,301.85	14,125,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,295,306.71	62,856,224.89

210301	Гэрэл, цахилгаан	5,314,806.71	5,431,911.89
210302	Түлш, халаалт	46,979,800.00	57,424,313.00
210303	Цэвэр, бохир ус	700	
2104	Хангамж, бараа материалын зардал	30,417,226.00	37,696,540.70
210401	Бичиг хэрэг	2,008,000.00	2,763,650.00
210402	Тээвэр, шатахуун	19,580,700.00	22,976,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,260,626.00	3,627,990.70
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,737,300.00	3,534,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,830,600.00	4,794,100.00
2105	Нормативт зардал	86,816,903.00	127,084,928.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	74,754,581.00	113,014,988.00
210502	Хоол, хүнс	9,727,322.00	11,019,940.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,335,000.00	3,050,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,565,860.00	34,169,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,907,000.00	4,661,500.00
210604	Урсгал засвар	15,658,860.00	29,508,200.00
2107	Томилолт, зочны зардал	5,404,000.00	5,967,000.00
210702	Дотоод албан томилолт	5,404,000.00	5,967,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,563,850.00	8,917,338.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,238,400.00	8,385,380.00
210803	Даатгалын үйлчилгээ	133,950.00	133,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	163,500.00	84,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		180,000.00
210807	Газрын төлбөр	28,000.00	67,508.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,083,600.00	1,653,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,083,600.00	1,653,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,442,833.29	1,046,675.11
2132	Бусад урсгал шилжүүлэг		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,442,833.29	1,046,675.11
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,442,833.29	1,046,675.11
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	24,696,169.48	-59,787,803.97
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)		
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	9,978,000.00	42,382,000.00
	Дотоод эх үүсвэрээр	9,978,000.00	42,382,000.00
222001	Тоног төхөөрөмж	9,978,000.00	42,382,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-9,978,000.00	-42,382,000.00
145	Бусад эх үүсвэр		
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал		
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		

VIII	нийт цэвэр мөнгөн гүйлгээ (8)=(3)+(6)+(7)	14,718,169.48	-102,169,803.97
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		107,437,785.60
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		5,267,981.63

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	276,351,125.19	201,528,408.82	407,428,257.47	885,307,791.48
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний есөлт, бууралт				
14	Үндсэн хөрөнгийн есөлт, бууралт				
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
16	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
17	Тайлант үеийн үр дүн			64,911,394.77	64,911,394.77
18				
19	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	276,351,125.19	201,528,408.82	472,339,652.24	950,219,186.25

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Харьц уулалт
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,667,581,600.00	1,142,475,694.37	525,105,905.63	68.51
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,667,581,600.00	1,100,093,694.37	567,487,905.63	65.97
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,667,386,600.00	1,099,047,019.26	568,339,580.74	65.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,055,650,800.00	730,062,587.67	325,588,212.33	69.16
210101	Үндсэн цалин	586,845,000.00	424,742,836.54	162,102,163.46	72.38
210102	Нэмэгдэл	374,723,000.00	231,589,319.13	143,133,680.87	61.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,658,000.00	12,608,000.00	-2,950,000.00	130.54
210104	Урамшуулал	84,424,800.00	61,122,432.00	23,302,368.00	72.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	126,132,800.00	90,638,800.00	35,494,000.00	71.86
210201	Тэтгэврийн даатгал	86,523,400.00	62,387,600.00	24,135,800.00	72.1
210202	Тэтгэмжийн даатгал	9,902,200.00	7,062,800.00	2,839,400.00	71.33
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,951,200.00	3,531,400.00	1,419,800.00	71.32
210204	Ажилгүйдлийн даатгал	4,951,200.00	3,531,400.00	1,419,800.00	71.32
210205	Эрүүл мэндийн даатгал	19,804,800.00	14,125,600.00	5,679,200.00	71.32
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	63,018,300.00	62,856,224.89	162,075.11	99.74
210301	Гэрэл, цахилгаан	5,600,000.00	5,431,911.89	168,088.11	97
210302	Түлш, халаалт	57,418,300.00	57,424,313.00	-6,013.00	100.01
2104	Хангамж, бараа материалын зардал	69,931,000.00	37,696,540.70	32,234,459.30	53.91
210401	Бичиг хэрэг	3,755,600.00	2,763,650.00	991,950.00	73.59
210402	Тээвэр, шатахуун	45,161,100.00	22,976,000.00	22,185,100.00	50.88
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,945,400.00	3,627,990.70	3,317,409.30	52.24
210404	Ном, хэвлэл	166,600.00		166,600.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,068,900.00	3,534,800.00	1,534,100.00	69.74
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,833,400.00	4,794,100.00	4,039,300.00	54.27
2105	Нормативт зардал	211,724,100.00	127,084,928.00	84,639,172.00	60.02
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	177,960,700.00	113,014,988.00	64,945,712.00	63.51
210502	Хоол, хүнс	28,130,000.00	11,019,940.00	17,110,060.00	39.18
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,633,400.00	3,050,000.00	2,583,400.00	54.14
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	103,141,700.00	34,169,700.00	68,972,000.00	33.13
210601	Багаж, техник, хэрэгсэл	64,938,200.00	4,661,500.00	60,276,700.00	7.18
210604	Урсгал засвар	38,203,500.00	29,508,200.00	8,695,300.00	77.24
2107	Томиллолт, зочны зардал	8,666,600.00	5,967,000.00	2,699,600.00	68.85
210702	Дотоод албан томиллолт	8,666,600.00	5,967,000.00	2,699,600.00	68.85
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,829,000.00	8,917,338.00	11,911,662.00	42.81
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	17,437,100.00	8,385,380.00	9,051,720.00	48.09

	үйлчилгээний төлбөр хураамж				
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	150,000.00		150,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	934,000.00	133,950.00	800,050.00	14.34
210804	Тээврийн хэрэгслийн татвар	404,500.00	84,500.00	320,000.00	20.89
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	186,000.00	66,000.00	120,000.00	35.48
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	559,000.00	180,000.00	379,000.00	32.2
210807	Газрын төлбөр	158,400.00	67,508.00	90,892.00	42.62
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,000,000.00		1,000,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,292,300.00	1,653,900.00	6,638,400.00	19.95
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,292,300.00	1,653,900.00	6,638,400.00	19.95
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	195,000.00	1,046,675.11	-851,675.11	536.76
2132	Бусад урсгал шилжүүлэг	195,000.00		195,000.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	195,000.00		195,000.00	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлэн захирагчдад олгох		1,046,675.11	-1,046,675.11	
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		1,046,675.11	-1,046,675.11	
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		42,382,000.00	-42,382,000.00	
	Дотоод эх үүсвэрээр		42,382,000.00	-42,382,000.00	
222001	Тоног төхөөрөмж		42,382,000.00	-42,382,000.00	
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		1,040,305,890.40	1,040,305,890.40	-
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ				
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого				
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ		64,718,300.00	-64,718,300.00	
132001	Орон нутгийн төсвөөс		64,718,300.00	-64,718,300.00	
133	ТӨСВИЙН ЗАХИРАГЧДААС НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ				
134			925,072,290.40	-925,072,290.40	
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих		925,072,290.40	-925,072,290.40	
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС		50,515,300.00	-50,515,300.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		50,515,300.00	-50,515,300.00	
124	БУСАД ЭХ ҮҮСВЭР				
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		107,437,785.60	-107,437,785.60	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		5,267,981.63	-5,267,981.63	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт санхүүжилтийн дансаар орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй болно.

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тайлант онд тус байгууллага нь “Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж байгаа төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, “Чанартай үйлчилгээ, хариуцлагатай, ёс зүйтэй тусламж үйлчилгээг хүргэх” гэсэн зорилтыг дэвшүүлэн ажилласан ба хүний нөөцийн тогтвортой байдал, багаар ажиллах чадвартай, мэргэшсэн байх, ёс зүйтэй байх, цагийн нягтралтай байх гэсэн зарчмуудыг үнэт зүйлсээ болгон ажиллалаа. Мөн 2024 онд 420 хүн хэвтэн эмчлүүлж, 2910 ор хоног ашиглаж, дундаж ор хоног 6.9 байна.

Гүйцэтгэлийн санхүүжилттэй холбоотойгоор 2021 оноос эхлэн өдрийн эмчилгээ, сэргээн засах, гэрээр үзүүлэх тусламж зэрэг эмчилгээ нэмэгдсэнтэй холбоотойгоор хэвтэн эмчлүүлэх хүний тоо буурах хандлагатай байна.

Эрүүл мэндийн төвийн 2024 оны батлагдсан төсөв нь 1,667,581.6 мянган төгрөг, 2024 оны 12-р сарын 31-ны байдлаар төсвийн гүйцэтгэлээр 1,142,475.6 мянган төгрөгийн орлого, санхүүжилттэй ажилласан байна.

Эрүүл мэндийн сайдын А/537 тушаалаар /Эмнэлгийн үйл ажиллагааг хангах/ нэмэлт санхүүжилт байхгүй, нийт 5,267.9 мянган төгрөгийн дансны үлдэгдэлтэй ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Эрүүл мэндийн тухай хууль, ЭМДЕГ-ын тогтоолууд, хууль журмууд, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Татварын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Шилэн дансны хууль, Төрийн болон орон нутгийн тухай хууль бусад холбогдох хууль, тогтоол, заавар, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төсвийн шууд захирагч батлагдсан төсөвт үндэслэн зарлагын гүйлгээг хянаж баталгаажуулснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол тосгоны төрийн сан холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичиг, зарлагын гүйлгээг хянаж байна.

Байгууллагын удирдлагын баг болон дотоод хяналтын багаас хэрэгжүүлж буй төлөвлөлтийг үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган аймгийн Гурванбулаг сумын ЭМТ-ийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Булган аймгийн Гурванбулаг сумын ЭМТ-ийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2023 оны А/229 дугаар журмаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 90,333.1 мянган төгрөгөөр буюу 9.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	107,437.70	5,267.90	-102,169.80
Авлага	17943	212,501.30	194,558.30
Бараа материал	81,958.20	74,042.60	-7,915.60
Үндсэн хөрөнгө	679,210.60	685,070.80	5,860.20
Нийт хөрөнгө	886,549.50	976,882.60	90,333.10
Өр төлбөр	1241.9	26663.4	25,421.50
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	276,351.10	276,351.10	0.00
Хуримтлагдсан үр дүн	407,428.20	472,339.60	64,911.40
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	201,528.40	201,528.40	0.00
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	886,549.50	976,882.60	90,333.10

Дээрх хүснэгтээс харахад бараа материал өмнөх оны үзүүлэлтээс 7,915.6 мянган төгрөгөөр буурч, үндсэн хөрөнгө 5,860.2 мянган төгрөгөөр өссөн харагдаж байна. Тайланд онд 71,640.7 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан байна

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг ЭМДС-гаас 925,072.2 төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн санал 2024 онд төлөвлөсөн дүнгээр хүртээмжтэй 525,106.0 мянган төгрөг хэмнэгдэж өр үүсгэлгүй үйл ажиллагаа явуулсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гурванбулаг сумын ЭМТ нь гүйцэтгэлийн санхүүжилтээр санхүүжиж 1 хөтөлбөр 4 зориулалт арга хэмжээний хүрээнд 1,667,581.6 төгрөгийг зарцуулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 1,142,475.6 мянган төгрөгийн санхүүжилтийг ЭМДЕГаараас 925,072.2 мянган төгрөгийн санхүүжилтийг авч зарцуулжээ.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71602-Эрүүл мэндийн тусламж	669,720.2	669,720.2	0	92.5%
2	80302-Нэг иргэн	57,026.0	57,026.0	0	97.6%
2	81603- Үндсэн тусламж				
3	83603-Дээд шатнаас хувиарласан	2,488.0	2,488.0	0	99.9%
	83601-ОУБ-аас олгосон санхүүжилт				100%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Булган аймгийн Гурванбулаг Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг "Майкрофт аудит" ХХК-ий аудитор Г.Майцэцэг, ахлах аудитор Б.Нарантуяа нар гүйцэтгэж, хяналтуудыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер, дарга, тэргүүлэх аудиторын албан тушаалын албан үүргийг тор орлон гүйцэтгэгч Ж.Энхцоодол нар хэрэгжүүлэв.

Булган аймгийн Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймгийн аудитын газарт 2025 оны 01 дугаар сарын 23-ны өдрийн 09 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,227,268.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 18,409.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 13,806.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуулийн хэрэгжилтэнд хяналт тавих бодлого, чиглэлийн дагуу ажиллажээ.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБООС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд 2024 онд нийт 159 мэдээ мэдээлэхээс хуулийн хугацаанд 143 мэдээг бүрэн мэдээлж хугацаа хоцорсон 16 мэдээ байна. 2 мэдээ хуулийн хугацаа болоогүй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Цалингийн шөнийн илүү цагийг бодохдоо Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.8-т заасны дагуу шөнийн цагийн нэмэгдэл хөлс /дундаж цалин хөлсийг нэг аравны хоёр дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлж /-ийг нэмж олгох заалтыг баримтлаж ажиллаагүй. Зөвлөмж өгөх.

2 ажилтанд 246,669 төгрөгний цалин илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 заалтыг баримтлаж ажиллаагүй. Төлбөрийн акт тогтоох .

"Нийгмийн даатгалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.2 дахь "Иргэний хуулийн 343,359 дүгээр зүйлд заасан ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ болон тэдгээртэй адилтгах гэрээгээр тохирсон цалин хөлснөөс шимтгэл суутгах" заалтыг баримталж ажиллаагүй Төлбөрийн акт тогтоох

Машин тоног төхөөрөмжийн эхний үлдэгдэл тайлангаас 1,000,000 төгрөгөөр зөрүүтэй байна . Энэ нь УСНББООС-12, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх" гэсэн заалттай нийцэхгүй байна. Залруулга.

Эд хариуцагч нь агуулахын бүртгэлийг Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан " Маягт заавар батлах тухай"-г стандартын дагуу хөтлөөгүй байна. Зөвлөмж.

Тайлант хугацаанд орлого, зарлага, шаардах хуудсыг нягтлан бодогч, няравын гарын үсэг зурж баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.5 "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна" гэж заасантай нийцэхгүй байна. Албан шаардлага өгөх.

Анхны өртөгөө нөхсөн хөрөнгүүдийг дахин үнэлэх, ашиглах боломжгүй хөрөнгүүдийг актлах зэрэг бүртгэлийн ажил хийгдээгүй байгаа нь Энэ нь УСНББООС-17 "Үндсэн хөрөнгө" заалтыг, Засгийн газрын 2014 оны 297 дугаар "Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох журам" -ыг 1 дүгээр хавсралт, "Үндсэн

хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаа, жилд байгуулах элэгдлийн хэмжээ " хэрэгжүүлж ажиллаагүй байна. Албан шаардлага .

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, актыг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.Зөвлөмжийн биелэлтийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт хариу хүргүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	271,8	1	271,8	100
Албан шаардлага					
Зөвлөмж	2		2		
Нийт дүн	3	271,8	3	271,8	100

/мянган төгрөгөөр/

Хэрэгжээгүй төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж байхгүй болно.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

ЭМД-сангаас эрүүл мэндийн байгууллагуудад эм, эмнэлгийн тусламж, үйлчилгээний хөлсийг гүйцэтгэлээр санхүүжүүлэхдээ эх олонлогийн, сиситемийн, эмч байцаагчийн гэсэн 3 төрлөөр хассан тул дотоод хяналтыг сайжруулах Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж , зориулалтын бус зардал гаргахгүй байх, жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө эд хөрөнгийн тооллогыг заавал хийж хэрэгжүүлж үлдэгдлийг баталгаажуулж хэвших, бараа материал, үнэ бүхий зүйлийн орлого, зарлагыг цэгцлэн шалгаж, нэр төрлийн бүртгэлийг эд хариуцагч бүрээр хөтлүүлж тайлан гаргуулан үлдэгдлийн бүртгэлтэй тулган шалгасан байх.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар уг баримт бичиг хүчин төгөлдөр болно","Анхан шатны бүрдэлгүй, ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно гэж тус тус заасан байдаг. Тиймээс компанийн эрх бүхий этгээдийн гарын үсэг тамга тэмдгээр баталгаажсан анхан шатны баримтыг үндэслэн нягтлан бодох бүртгэлээ хөтөлж байх

Санхүүгийн тайлан болон Анхан шатны баримтыг үдэхдээ Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, НББ тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу архивлан баримтжуулж, дотоод хяналтыг сайжруулахыг санхүүгийн албанд зөвлөж байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 509,169 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 509,169 мянган төгрөгийн төлбөрийн 2 акт тогтоож, 2 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Эмийн 2 ажилтанд 246,6 мянган төгрөгний цалин илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 заалтыг баримтлаж ажиллаагүй.

5.1.2 "Нийгмийн даатгалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.2 дахь "Иргэний хуулийн 343,359 дүгээр зүйлд заасан ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ болон тэдгээртэй адилтгах гэрээгээр тохирсон цалин хөлснөөс шимтгэл суутгах" заалтыг баримталж ажиллаагүй

5.2 Албан шаардлага

Албан шаардлага бичигдээгүй болно.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								



БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ТӨЛБӨРИЙН АКТ

2025 оны 02 дугаар сарын 19

Дугаар 02/26 - 25452520
ЗУА - 2025/09/НА - СИА - ТӨЛБ

Булган сум

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Булган аймгийн Гурванбулаг сумын ЭМТ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хоёр ажилтанд 246,669.0 (Хоёр зуун дөчин зургаан мянга зургаан зуун жаран есөн) төгрөгийн цалин илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 заалтыг баримтлаж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.1-д "Төсвийн үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна." гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.5-д "бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн." гэж заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1.Актаар тогтоосон 246,669.0 (Хоёр зуун дөчин зургаан мянга зургаан зуун жаран есөн) төгрөгийг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын Төрийн сан банкин дахь аймгийн төсвийн орлогын 100040051005 тоот дансанд төвлөрүүлэх;

2.Актын биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Гурванбулаг сумын ЭМТ-ийн дарга (А.Лхамдулам), нягтлан бодогч (Д.Баасанхүү) нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ТУШААЛЫН

АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

"МАЙКРОФТ АУДИТ" ХХК-ИЙ
ЗАХИРАЛ, АУДИТОР

Ж.ЭНХЦООДОЛ

Г.МАЙЦЭЦЭГ



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ТӨЛБӨРИЙН АКТ**

2025 оны 02 дугаар сарын 19

Дугаар 09/15 - 25452520

Булган сум

ЖУА - 2025/091/НА-СТА - 7213

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Булган аймгийн Гурванбулаг сумын ЭМТ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.2 дахь "Иргэний хуулийн 343,359 дүгээр зүйлд заасан ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ болон тэдгээртэй адилтгах гэрээгээр тохирсон цалин хөлснөөс шимтгэл суутгах" заалтыг баримталж ажиллаагүй 262,500.0 (Хоёр зуун жаран хоёр мянга таван зуун) төгрөг суутгаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.1-д "Төсвийн үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна." гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.5-д "бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн." гэж заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Актаар тогтоосон 262,500.0 (Хоёр зуун жаран хоёр мянга таван зуун) төгрөгийг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын Төрийн сан банкин дахь аймгийн төсвийн орлогын 100040051005 тоот дансанд төвлөрүүлэх;

2.Актын биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Гурван булаг сумын ЭМТ-ийн дарга (А.Лхамдулам), нягтлан бодогч (Д.Баасанхүү) нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ТУШААЛЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

"МАЙКРОФТ АУДИТ" ХХК-ИЙ
ЗАХИРАЛ, АУДИТОР

Ж.ЭНХЦООДОЛ

Г.МАЙЦЭЦЭГ